



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 10 сарын 24 өдөр

Дугаар А/197.

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл шинээр олгох,
хугацаа сунгах, хаягийн өөрчлөлт бүртгэх,
чиглэл цуцлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.10, 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.2, 10.1.5, 15 дугаар зүйлийн 15.12.2, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.2, 19.3.4, 19.18, 19.20.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Эрүүл мэндийн сайдын 2013 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/400 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тусгай зөвшөөрөл олгох комиссын 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 13 дугаар хурлын шийдвэрийн дагуу эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох, чиглэл нэмэх байгууллагын нэрсийг нэгдүгээр, тусгай зөвшөөрлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохгүй байгууллагын нэрсийг хоёрдугаар, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах, хаягийн өөрчлөлтийг бүртгэх байгууллагын нэрсийг гуравдугаар, тусгай зөвшөөрлийн чиглэлийг цуцлах байгууллагыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байгууллагыг арга зүйгээр хангаж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газар (Л.Зэндмаа), Чанарын хяналтын газар (Г.Номин) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Л.Батзориг)-т даалгасугай.

ДАРГА



Д.НАРАНТУЯА

1422 01197

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын даргын 2022 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн 1117 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХ,ЧИГЛЭЛ НЭМЭХ БАЙГУУЛЛАГУУД

№	Байгууллагын нэр /РД/	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг байршил	Хүчинтэй хугацаа
Нэг. Тусгай зөвшөөрөл шинээр олгох байгууллага				
1	Эрхэт тайж ХХК РД-5608694 901135034	Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	БЗД, 14-р хороо, Аман хуур-2, 2 давхарт	2025.10.05
2	Глобал атоми Монголиа ХХК РД6784607 9019097329	Биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	ХУД, 2-р хороо, Монгол нэхмэл байр	2025.10.05
3	Энержи кристал мед ХХК РД-6758053 9011831613	Эм импортлох, ханган нийлүүлэх	СХД, 20-р хороо, товчооны зам гудамж, 56 тоот, 1,3 давхарт	2025.10.05
Хоёр. Тусгай зөвшөөрлийн чиглэл нэмсэн байгууллага				
4	Нахиа-Импекс ХХК РД-2048833 9011023106	Биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	СБД, 2-р хороо, Нарны зам гудамж 18	2025.10.05
5	Аму Мед ХХК РД-5906539 9011408095	Биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	СБД, 1-р хороо, ТГ төвийн 603, 606, 502 тоот	2025.10.05

--ooOOoo--

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын даргын 2022 оны 10 дугаар сарын 24-ны өдрийн 8/192 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

АЖЛЫН БАЙРНЫ ҮНЭЛГЭЭГЭЭР СТАНДАРТЫН ШААРДЛАГА
ХАНГААГҮЙГЭЭС ДЭМЖИГДЭЭГҮЙ БАЙГУУЛЛАГЫН НЭР

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл
Эрүүл мэндийн сайдын 2021 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/400 дугаар тушаалын 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтад заасны дагуу 1 жилийн хугацаанд дахин хүлээн авахгүй байх байгууллага		
1	ИРОМАКС ФАРМАСИ ХХК РД - 6791794 9011834077	Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх

--ooOOoo--

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын даргын 2022 оны 10 дугаар сарын 24-ны өдрийн 4192 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦАА СУНГАХ, ХАЯГИЙН
ӨӨРЧЛӨЛТИЙГ БҮРТГЭХ БАЙГУУЛЛАГУУД

№	Байгууллагын нэр /РД/	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг байршил	Хүчинтэй хугацаа
Нэг. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах байгууллага				
1	Дөмөн ХХК РД-5937418 9011532071	Эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	БГД, 20-р хороо, Нөхөрлөлийн гудамж, үйлдвэрлэлийн бүс, Оргилмөнх трейд ХХК-ны байр 301- 304 тоот	2027.09.02
2	КОЭ ХХК РД-2829711 9011212090	Эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	ХУД, 11-р хороо Их Монгол улсын гудамж Маршал таун хотхон, Кинг тауэр 118-1 тоот	2027.09.16
Хоёр.Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, хаягийн өөрчлөлтийг бүртгүүлэх байгууллага				
3	СИТИГАЗ ХХК РД-5638658 9011371056	Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	ХУД, 3-р хороо, Эв нэгдлийн гудамж, Айвико ХХК-ны үйлдвэрийн байр	2027.09.10
4	ТУНАМАЛМЕД ХХК РД-2831457 9011032140	Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	ЧД, 3-р хороо, Жуулчны гудамж,5-р корпус, урт цагааны 3 давхарт	2027.09.16
5	Хайтан арвижих ХХК РД-6353053 9011759088	Эм,эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	БГД, 24-р хороо, Үйлдвэрийн төвийн бүс, үйлдвэрийн гудамж 52В байр 1 давхарт	2027.10.25

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын даргын 2022 оны 10 дугаар сарын 24-ны өдрийн 9/197 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЧИГЛЭЛИЙГ ЦУЦЛАХ
БАЙГУУЛЛАГА

№	Байгууллагын нэр /РД/	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг байршил	Чиглэл цуцлах
Нэг. Тусгай зөвшөөрлийн чиглэлийг цуцлах				
1	КОЭ ХХК РД-2829711 9011212090	Шүдний эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	ХУД, 11-р хороо Их Монгол улсын гудамж Маршал таун хотхон, Кинг тауэр 118-1 тоот	Шүдний эм импортлох, ханган нийлүүлэх тусгай зөвшөөрлийн чиглэлийг цуцлах

--ooOOoo--